



**ХҮМҮҮНЛЭГИЙН
УХААНЫ
ИХ СУРГУУЛЬ**

Бүтээлч оюун ухаан таны ирээдүйн амжилт

**ХИС-ийн МАГИСТРАНТ, ДОКТОРАНТУУДАД
ЗОРИУЛСАН СУДАЛГААНЫ ЧИГЛЭЛ,
СУДАЛГААНЫ ҮНДСЭН АСУУДЛУУД**

**Эрдмийн Зөвлөлийн 2019 оны 03 сарын 15-ны
өдрийн хурлаар хэлэлцэн батлав**

**1. МЕНЕЖМЕНТ, ЭДИЙН ЗАСАГ, БИЗНЕС, МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦААНЫ
ХАМТАРСАН ЧИГЛЭЛЭЭР**

Судалгааны чиглэл	Судлах үндсэн асуудлууд
<i>Гарааны бизнес ба мэдээллийн ашиглалт</i>	Гарааны бизнесийн маркетингийн асуудлууд, Мэдээллийн хүртээмжтэй байдалд хийсэн шинжилгээ, Хэрэглэгчийн зан төлөвт гарч буй өөрчлөлт, тохирсон маркетингийн арга хэрэгслийг тодорхойлох
<i>Мэдээллийн технологи ба бизнесийн шинэ загвар</i>	Сошиал медиа, дижитал маркетингийн оновчтой шийдэл, Дижитал маркетингийн харьцуулсан судалгаа, Контент маркетингийн тулгамдсан асуудлууд, хөгжлийн боломж, технологийн дэвшлийг байгууллагын менежментэд ашиглах, бизнесийн инновац, стратегийн асуудал, PR менежмент, нейромаркетинг

**2. ЭДИЙН ЗАСАГ, БИЗНЕСИЙН УДИРДЛАГА, ХЭРЭГЛЭЭНИЙ
МАТЕМАТИКИЙН ХАМТАРСАН ЧИГЛЭЛЭЭР**

Судалгааны чиглэл	Судлах үндсэн асуудлууд
<i>Бизнесийн тулгамдсан асуудлуудын шийдэл /кейс судлал/</i>	Жижиг дунд бизнесийн асуудал, бизнесийн байгууллагын маркетинг, хүний нөөц, санхүү, үйлдвэрлэл, үйл ажиллагааны оновчтой шийдэл, бизнесийн орчин, хэрэглэгчийн болон ажиллагсдын сэтгэл ханамжийг дээшлүүлэх асуудлууд, бизнесийн зардлыг бууруулах боломж, нийлүүлэлтийн сүлжээний асуудал болон оновчлол, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд байршуулах асуудал, олон улсын зах зээлд бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх асуудлууд, төслийн оновчтой менежмент
<i>Бизнесийн байгууллагын эдийн засгийн үр ашгийн шинжилгээ, нөлөөллийн үнэлгээ</i>	Ажиллагсдын гүйцэтгэлийг KPI ашиглан үнэлэх боломж, эдийн засгийн үр ашиг, Арилжааны банкуудын чанаргүй зээлийн судалгаа, зээлийн бодлогын шийдэл, Цахим мөнгөний хэрэглээний эдийн засгийн болон бусад нөлөөлөл, Сошиал пей үйлчилгээний тулгамдсан асуудал, шийдэл, Жижиг дунд бизнесийн санхүүжилтийн боломжуудыг тодорхойлох нь, Жижиг дунд бизнесийн эрсдэлийн үнэлгээ, төслийн эдийн засгийн болон хөрөнгө оруулалтын үнэлгээ, Аялал жуулчлалын нийгэмд үзүүлж буй нөлөөллийн үнэлгээ*, аялал жуулчлалын эдийн засагт үзүүлж буй нөлөөллийн үнэлгээ*, бизнесийн байгууллагын ашигт

	ажиллагаа, нөлөөллийн шинжилгээ*
<i>Эдийн засаг, бизнесийн оновчтой загварыг тодорхойлох</i>	Монгол улсын макро эдийн засгийн тулгамдсан асуудлууд, эдийн засгийн өсөлтийг хангахуйц санхүүгийн загвар, Хүн амын шилжих хөдөлгөөний нийгэм, эдийн засгийн нөлөөлөл, бодлогыг оновчлох нь, мал аж ахуйн гаралтай экспортыг нэмэгдүүлэх арга замууд/ ноос ноолуурын чиглэлийн судалгаа, мах махан бүтээгдэхүүний чиглэлийн судалгаа, арьс ширэн бүтээгдэхүүний чиглэлийн судалгаа/*, аялал жуулчлалын салбарын тулгамдсан асуудлууд, макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг сайжруулах боломж, нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээ
<i>Бизнесийн байгууллагын маркетинг, стратегийн оновчтой шийдэл</i>	Зах зээлийн судалгаа, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, олон улсын зах зээлийн боломжийн судалгаа, бизнесийн стратегийн асуудлууд, үйлчилгээний маркетинг, брэндийн шийдвэр

* - Бизнесийн байгууллагууд болон судалгааны байгууллагуудын захиалгат судалгаа

3. ХҮНИЙ НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТ, БОЛОВСРОЛ СУДЛАЛ, СЭТГЭЛЗҮЙН ХАМТАРСАН ЧИГЛЭЛЭЭР

Судалгааны чиглэл	Судлах үндсэн асуудлууд
<i>Суралцагчийн сэтгэл зүйн хэв шинж, хэрэгцээнд тулгуурласан боловсрол олгох</i>	Суралцагсдын хандлагад гарч буй өөрчлөлтийн судалгаа /сэтгэл зүйн, цаг хугацааны хүчин зүйлийн хувьд/, Жендерийн харьцуулсан судалгаа, Төрийн өмчийн болон хувийн их дээд сургуулиудын оюутнуудын чадамжийн харьцуулсан судалгаа, Суралцагсдын зан төлөвт гарч буй өөрчлөлт ба сургалтын арга барил
<i>Байгууллагын хүний нөөцийн сэтгэл зүйн асуудлууд</i>	Байгууллага дахь ажиллагсдын сэтгэл заслын хэрэгцээг тодорхойлох, ажиллагсдын стрессийн түвшин, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээ, ажлын байрны дарамтыг бууруулж, эерэг орчинг бүрдүүлэх арга зүйн асуудал, сэтгэл зүйн онцлогт тохирсон сургалтын арга барил, байгууллагын соёлын болон зан төлөвийн судалгаа, хүний нөөцийн бүрдүүлэлт, сонголтод нөлөөлөх хүчин зүйлс, ажиллагсдын сэтгэл ханамжид нөлөөлөх хүчин зүйлс

4. НИЙТИЙН УДИРДЛАГА, МЕНЕЖМЕНТ, ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТАРСАН ЧИГЛЭЛЭЭР

Судалгааны чиглэл	Судлах үндсэн асуудлууд
<p><i>Төрийн бодлогын асуудал</i></p>	<p>Бүсчилсэн хөгжлийн бодлогын шийдлүүд, кластерын асуудал, Торгоны замын бодлого, эдийн засаг, гадаад худалдааны бодлогын асуудлууд, Хүн ам зүйн бодлогын нөлөөлөл, оновчтой шийдэл, Инновацын бодлого, мэдлэгт суурилсан засаглалын загвар, Төрийн бодлого тодорхойлоход олон нийтийн оролцоог хангаж буй байдал, Салбарын бодлогын хэрэгжилтэд нөлөөлөгч хүчин зүйлүүд, загварчлалд суурилсан судалгаа, Бодлогын харьцуулсан судалгаа, Тогтвортой хөгжлийн хүчин зүйлүүд, бодлогын үр нөлөө, Салбар хоорондын бодлогын уялдаа, оновчтой загвар, Бодлогын үр дүнгийн шинжилгээ / цаг хугацааны хүчин зүйл, эрх баригч намуудын үзэл баримтлал/, олон улсын байгууллагуудын төрийн бодлогод нөлөөлөх нөлөөлөл, Төрийн бодлогын Think tank бүлгүүдийн төлөвшил, бодлогын шийдвэр гаргалтад нөлөөлөх нөлөөлөл, Иргэдийн улс төр, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх замаар бодлого тодорхойлоход оролцох оролцоог нэмэгдүүлэх нь, Төвлөрлийг сааруулах бодлогын оновчтой шийдэл, загвар, МУ-ын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн цахим шилжилт, Нийгмийн хамгааллын бодлого, оновчтой шийдэл, Нийгмийн бодлогын үр нөлөөг хүний хөгжлийн индексээр хэмжих нь, Эдийн засгийн бодлогын оновчтой шийдэл, загвар /ядуурлыг бууруулах, ажилгүйдлийн түвшинг бууруулах чиглэлээр/</p>
<p><i>Нийтийн удирдлага, төрийн захиргааны менежмент</i></p>	<p>Төрийн байгууллагуудын тогтолцооны шинэчлэл, Төрийн захиргааны байгууллагуудын менежментийн оновчтой загварыг тодорхойлох нь, Байгалийн нөөцийн хамтын менежментийн загвар, Цахим засаглалын оновчтой хэлбэр, Төрийн захиргааны байгууллагуудын хүний нөөцийн тулгамдаж буй асуудал, шийдэл, Төрийн захиргааны байгууллагуудын хүний нөөцийн мэргэжлийн ур чадварын асуудал, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн оновчтой хэлбэр, Төрийн маркетинг, Орон нутаг дахь төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн асуудал, Салбарын босоо удирдлага, уялдаа холбооны оновчтой загвар, Нийгэмд чиглэсэн хөтөлбөрийн үнэлгээ, үр ашгийн асуудал, Төрийн байгууллагууд, ашгийн бус байгууллагууд, Засгийн газрын бус байгууллагуудын зохион байгуулалтын оновчтой загвар,</p>

	Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний ажиллагсдын ажлын байрны стрессийн түвшин, Төсвийн хуваарилалтын оновчтой шийдэл, Орон нутгийн хөгжлийн сангийн орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр, нөлөө
--	--

5. НИЙТИЙН УДИРДЛАГА, БОЛОВСРОЛЫН УДИРДЛАГА, ОЛОН УЛС СУДЛАЛЫН ХАМТАРСАН ЧИГЛЭЛЭЭР

Судалгааны хүрээ	Судлах үндсэн асуудлууд
<i>Дээд боловсролын хөгжлийн хандлага ба менежментийн шинэчлэл</i>	Олон улсын дээд боловсролын хөгжлийн хандлага, өөрчлөлт, шинэчлэл, тэдгээрийн Монголын дээд боловсролд үзүүлэх нөлөөлөл, дээд боловсролын бодлого, засаглалын харьцуулсан судалгаа. Хөтөлбөрийн менежментийн харьцуулсан судалгаа; Сургалтын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын тулгамдсан асуудлууд; Хүний нөөцийн удирдлага (маркетингийн удирдлага, гүйцэтгэлийн удирдлага, чанарын удирдлага)-ыг сайжруулах арга зам, загвар; Дээд боловсролын хөгжилд түлхэц болох боловсролын интернационалчлалын боломжуудын судалгаа
<i>Глобалчлалын нөхцөлд Монголын дээд боловсролын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх</i>	Олон улсын дээд боловсролын менежментийн хэв загвар, туршлагын судалгаа; Байгууллагын академик соёл, академик стандарт, чанарын үнэлгээний судалгаа ба глобал орон зайд нэгдэх боломж; Хамтарсан хөтөлбөрүүд хэрэгжүүлэх боломжийн судалгаа; Судалгаа ба энтреpreneurshipийн үндсэн асуудлууд; Зайн ба он-лайн сургалтыг нэвтрүүлэх боломжийн судалгаа; Мэдлэгийн hub ба сүлжээний хэрэглээний судалгаа; Дижиталчлалын үеийн дээд боловсролын салбарт гарч буй өөрчлөлтийн судалгаа

6. ОЛОН УЛС СУДЛАЛ, ЭДИЙН ЗАСАГ, БИЗНЕСИЙН ХАМТАРСАН ЧИГЛЭЛЭЭР

Судалгааны чиглэл	Судлах үндсэн асуудлууд
<i>Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах</i>	Эдийн засгийн аюулгүй байдал, нөлөөлөгч хүчин зүйлсийн шинжилгээ, Эко бүтээгдэхүүнийг дэмжих бизнесийн загвар, Импортыг орлуулах бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих бодлого, Гадаад худалдааны бодлогоор тэнцвэрийг хангах асуудал, Гадаад худалдааны бодлогоор эдийн засгийн өсөлтийг дэмжих боломж

<p align="center"><i>Ажиллах хүчний хомсдолыг шийдэх арга зам</i></p>	<p>Олон улсын ажиллах хүчний шилжилт эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, Аутсорсинг ашиглан ажиллах хүчний хомсдолыг шийдэх арга зам, ОУ - ын ажиллах хүчний шилжилт, нийгмийн нөлөөлөл</p>
---	--

7. ОЛОН УЛС СУДЛАЛ, СОЁЛ, ХЭЛ СУДЛАЛЫН ХАМТАРСАН ЧИГЛЭЛЭЭР

Судалгааны чиглэл	Судлах үндсэн асуудлууд
<p align="center"><i>Олон улсын харилцаа, хэл, соёлын харьцуулсан судалгаа</i></p>	<p>Монгол болон харь үндэстний нийгмийн ба хэлний сэтгэлгээний харьцуулсан судалгаа (үндэстнүүдийн нийгмийн сэтгэлгээний нийтлэг болон онцлог, хэлний сэтгэлгээний хөгжил ба төлөвшил сэтгэлгээнд соёлын нөлөөлөл), Үндэстний хэл, соёлын ижилсэл, ондоошлын (identify) харьцуулсан судалгаа, Дэлхийн Монгол угсаатны харьцуулсан судалгаа (хэлний нийгэмшил, сэтгэлгээ, зан заншил, шашин, соёл, урлаг)</p>
<p align="center"><i>Олон улсын харилцаа, сэтгэл судлалын харьцуулсан судалгаа</i></p>	<p>Гадаад бодлогын шийдвэр гаргалтад улс төрийн удирдагчийн зан төлөв нөлөөх нь, Байнга төвийг сахих санаачилгын субъектив хүчин зүйлсийн судалгаа, Улс орнуудын соёл хоорондын харилцаа</p>

8. ХЭЛ ШИНЖЛЭЛ, СЭТГЭЛ СУДЛАЛ, БОЛОВСРОЛ СУДЛАЛ, ТАРХИ СУДЛАЛЫН ХАМТАРСАН ЧИГЛЭЛЭЭР

Судалгааны чиглэл	Судлах үндсэн асуудлууд
<p align="center"><i>Когнитив ба нейро хэл шинжлэл, сэтгэл судлалын солбилцол дээрх судалгаа</i></p>	<p>Когнитив хэл шинжлэл:</p> <ul style="list-style-type: none"> • Хүүхдийн хэл ярианы хөгжил, чадавхи; хэлзүйн концептуал бүтэц, хэлний сэтгэлгээний механизм, дуу авиа ялгах, морфологийн ба синтактик бүтцийг эзэмших. Үгсийн сан ба хэлзүйн бүтцийн холбогдол, когнитив семантик, имаж схем, прототип, радиал ба схематик сүлжээ; загваруудаар категоруудыг эрэмбэлэх. Унших үйл явц ба семантик ой санамж, хурдтай сканинг уншлага ба ой тогтоомж, өнгө илэрхийлэх болон ой тогтоомжийн универсал, семантик ой болон ойлголтын холбогдол. • Ментал дүрслэл, тэдгээрийг илэрхийлэх; мэдээллийг категорчилох загварууд, метафорын когнитив анализ, дискурсын бүтцийн когнитив анализ; соёлын орчин болон хам сэдвийг когнитив загваруудаар илэрхийлэх, когнитив антропологи болон соёлын универсал, хэлний сэтгэлгээг математик аргаар загварчлах, корпус судлалд когнитив загварууд

	<p>хэрэглэх, дижитал имижийг боловсруулах, илэрхийлэхэд гурван хэмжээст системүүдийг хэрэглэх</p> <p>Нейро хэл шинжлэл:</p> <ul style="list-style-type: none"> Хэлний сэтгэлгээний тархин дахь биологийн суурь, баруун ба зүүн тархины локализац, тархины функцууд ба сэтгэлгээний хэлбэрүүд; хэл ярианы хөгжлийг сношлох, хэл ярианы согог (афази, дислех, дисграф). Семантик интерпретац, метафор сэтгэлгээ, комплекс маппинг, символик болон нейро-тооцооллын харилцан хамаарал. Харааны болон хэлбэр дүрсийн перцепци, ерөнхий алгоритмууд; ярих, ойлгох процессын нейро хэлшинжлэлийн анализ, хоёр хэлийг эзэмших вербал стратеги ба хэлний сэтгэлгээ, гадаад хэл сурахад төрөлх хэлний нөлөөлөл: ухамсарт ба ухамсарт биш мэдлэг ба дотоод хэлэхүй, тархины долгионууд, энерги дамжуулах үйл явц ба дотоод хэлэхүйн холбогдол.
<p><i>Тархи судлал, сэтгэл судлалын солбилцол дээрх судалгаа</i></p>	<p>Когнитив судлал</p> <ul style="list-style-type: none"> Хүний когнитив функц, анхаарал, ой тогтоомж, орон зайн мэдрэхүй, когнитив хөгжил, харааны, сонсох болон хүртэхүйн. хүлээн авах механизм, учир шалтгааны холбогдлыг үндэслэн тодорхойлох механизм. Символик, коннектив ба динамик систем, параллел тархалтын процесс (РДР), боотстраппинг блендинг/ кластеринг. <p>Тархи судлал:</p> <ul style="list-style-type: none"> Когнитив нейро-сэтгэл судлал: нейро-сэтгэл судлал, билингвизм, нейро хэлшинжлэл, позитив сэтгэл судлал ба нейро шинжлэх ухаан, хүний хөгжлийн сэтгэл судлал, сэтгэл судлалын судалгааны арга, хэл эзэмшихүй ба когнитив психологи, сэтгэлгээний орон зай ба оюун ухаан, хэл сэтгэхүй хүчин зүйлийн анализ.
<p><i>Хэлний типолог, Монгол хэл шинжлэлийн солбилцол дээрх судалгаа</i></p>	<ul style="list-style-type: none"> Төрөл бус хэлний өгүүлбэр зүйн бүтцийн анализ Төрөл бус хэлний утга зүйн харьцуулсан анализ Монгол хүнд гадаад хэл заах хэл шинжлэлийн үндсийг боловсронгуй болгох судалгаа
<p><i>Хэл шинжлэл, орчуулга судлалын солбилцол дээрх судалгаа</i></p>	<ul style="list-style-type: none"> Орчуулга судлал ба танихуйн шинжлэх ухаан: орчуулга дахь танин мэдэхүй болон соёлын хамаарал: метафорын орчуулга ба соёлын аспект, орчуулга ба хос хэл, киноны орчуулга ба дискурс,

	<p>уран зохиолын орчуулга ба найруулга зүй,</p> <ul style="list-style-type: none"> • Хэлмэрчлэл ба танин мэдэх үйл ажиллагаа, хам ба цуваа цагийн орчуулга, танин мэдэхгүйн үйл ажиллагаа ба тэмдэглэгээний техник
--	---

9. БОЛОВСРОЛ СУДЛАЛ, СЭТГЭЛ СУДЛАЛЫН ХАМТАРСАН ЧИГЛЭЛЭЭР

Судалгааны чиглэл	Судлах үндсэн асуудлууд
<i>Сургах, сурах онол арга зүй, когнитив сэтгэл судлалын солбилцол дээрх</i>	<ul style="list-style-type: none"> • Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын стандарт, хөтөлбөр, агуулгыг боловсронгуй болгох • Ерөнхий боловсролын сургуулийн суралцагсдын танин мэдэх үйл ажиллагааны сэтгэл зүйн харьцуулсан судалгаа • Ерөнхий боловсролын сургуулийн гадаад хэлний сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйг боловсронгуй болгох

10. ОЛОН УЛС СУДЛАЛ, ЭДИЙН ЗАСАГ, БИЗНЕСИЙН ХАМТАРСАН ЧИГЛЭЛЭЭР

Судалгааны чиглэл	Судлах үндсэн асуудлууд
<i>Геополитикийн хүчин зүйлсийн судалгаа</i>	Олон улсын эдийн засаг, бизнесийн харилцаанд нөлөөлж буй геополитикийн хүчин зүйлсийн судалгаа,
<i>Орон судлал, бизнесийн харьцуулсан судалгаа</i>	Орон судлалын тулгамдсан асуудлын харьцуулсан судалгаа (улс төр-эдийн засаг, бизнес),
<i>Олон улсын харилцаа, бизнесийн interaction судалгаа</i>	Нийгэмчлэх үйл явцын эерэг, сөрөг үр дагаврын харьцуулсан судалгаа, Гадаад харилцаанд суурилсан энтреpreneиршипийг хөгжүүлэх нь

11. КОМПЬЮТЕРЫН ГРАФИК ДИЗАЙН, МАРКЕТИНГ, ДИЖИТАЛ СЭТГҮҮЛЗҮЙН ХАМТАРСАН ЧИГЛЭЛЭЭР

Судалгааны чиглэл	Судлах үндсэн асуудлууд
<i>Сэтгүүл зүйн глобал чиг хандлага ба мэдээлэл бүтээх, боловсруулах, түгээх үйл ажиллагааны технологийн шинэчлэл</i>	Баримт нягтлах, баталгаажуулах үйлчилгээ, Төлбөртэй контент, Нийгмийн сүлжээний хэрэгслүүд, Мобайл сэтгүүл зүй, хөгжүүлэлт, VR /virtual reality/, AR/augmented reality/, Хиймэл оюун ухаан ба контент, Мэдээлэл цуглуулах, боловсруулах шинэ программ хангамж, Апликайшнүүд, Хуурамч мэдээлэл, үр нөлөө, тархалт

<p><i>Монголын сэтгүүл зүй дэх нийгмийн тулгамдсан асуудлын талаарх мэдээллийн үр нөлөөг дээшлүүлэх</i></p>	<p>Мэдээлэл хүлээн авагчийн сэтгэл зүй, Экологийн нийтлэлүүд, үр нөлөө, сөрөг мэдээлэл, Дуулиан шуугиантай мэдээлэл, өсвөр үеийнхнийг мэдээллийн хүчирхийллээс хамгаалах шаардлага, Z үеийнхэн ба уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгсэл, Нийгмийн сүлжээ сайтууд ба хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээллийн хүртээмж, Цуврал нийтлэлийн үр нөлөө, Сэтгүүлч мэргэжлийн үнэлэмж, Хэвлэл мэдээллийн боловсрол, Соёлын түрэмгийлэл, Хүүхдийг нийгэмшихэд хэвлэл мэдээллийн үзүүлэх үр нөлөө</p>
---	--

